



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэйшнл ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Капитал инвестмент фонд” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Нэйшнл ассет менежмент ҮЦК” ХХК /М.Мэргэнбаатар/-д үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

2/ “Капитал инвестмент фонд” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;

3. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН